

БАГА БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ЭРҮҮЛ МЭНД



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

ЭРҮҮЛ МЭНД

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ 2

БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж 5

Хоёр: Нэгж үнэлгээний жишиг даалгавар 8

2.1. Сонгох даалгаврын жишээ, аргачлал 8

2.2. Задгай даалгаврын жишээ, аргачлал 10

Гурав: Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал..... 20

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүй

Эрүүл мэнд хичээлийн хувьд суралцахуйн удирдамжид тусгасан үндсэн 6 чиглэл буюу бүлэг сэдвийг нэгж болгон авсан. Үнэлгээний нэгж нь бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин дэх бүх ангид ижил байна. Энэ нь боловсролын түвшин тус бүрт сурагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг тэдгээр нэгж бүрээр үнэлж, үр дүнг тооцох давуу талыг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл, үнэлгээний нэгжийг ашиглан хөндлөн болон босоо байдлаар үнэлгээг хийх бүрэн боломжтой юм. Эдгээр 6 нэгж тус бүрээр сурагчийн ахиц дэвшлийг анги тус бүрт төдийгүй боловсролын түвшин тус бүрт сурагчид өөрсдөө болон хөндлөнгөөс үнэлж, үр дүнг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийж болно.

Суралцахуйн үр дүн нь бидний хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал юм. Тиймээс суралцахуйн үр дүнг боловсруулахдаа дутууг нөхөх зарчмыг баримталсан болно. Тус зарчимд тулгуурлан дараах алхмын дагуу тунгаан бодож суралцахуйн үр дүнг томьёолсон. Үүнд:

- Одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлыг тодорхойлох
- Одоогийн болон хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлын хооронд ямар зөрүү байгааг олж илрүүлэх
- Мэдлэг, чадвар, хандлагатай холбоотой ямар зүйлийг суралцах шаардлагатай байгааг тодорхойлох
- Тус зөрүү буюу дутуу зүйлийг хэрхэн нөхөхийг тодорхойлох

Нэгж тус бүрийн хүрээнд одоогийн нөхцөл байдлыг бодит мэдээ баримт, тулгамдсан асуудалд үндэслэн тодорхойлсон. Тухайлбал, хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд нэгжийн хүрээнд хүүхэд өсвөр үеийнхэнд нас, сэтгэл зүйн онцлогтой холбоотой ямар асуудлууд нийтлэг тулгамддаг талаарх бодит мэдээ баримтыг ашиглан одоогийн нөхцөл байдлыг төсөөлөн тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, тухайн нэг ангийн түвшинд буюу тодорхой нэг насанд сурагчдад хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэндтэй холбоотой ямар асуудал тулгардаг болохыг тодорхойлно.

Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал нь одоогийн нөхцөл байдал шийдвэрлэгдсэн байх тэр цаг мөч бөгөөд энэ нь ямар байдлаар шийдвэрлэгдсэн байхыг томъёолсон томъёоллыг хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал гэж үзэж болно.

Одоогийн болон хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлыг тодорхойлсны дараа эдгээрийн хооронд ямар зөрүү байгааг илрүүлнэ. Үүний тулд одоогийн нөхцөл байдлаас хүсэж буй нөхцөл байдалд хүрэхэд юу дутаад байгааг олж тогтооно. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр нөхцөл байдлын зөрүүг үүсгэж буй шалтгааныг тодорхойлно.

Ийнхүү тус шалтгаан бүхий цоорхойг олж илрүүлэн, түүнийг хэрхэн нөхөхийг томъёолсон томъёолол нь суралцахуйн үр дүн болно. Энэ нь сурагчдын эрүүл мэндийн боловсролын хэрэгцээтэй нягт уялдаатай юм. Цоорхой нөхөгдөж, өөрчлөлт гарсан эсэхийг буюу хүссэн үр дүндээ хүрсэн эсэхийг тодорхойлж буй байдал нь үнэлгээ юм. Тус өөрчлөлтийг хэрхэн хэмжихийг илэрхийлж буй зүйл нь үнэлгээний арга юм.

“Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд” нэгжийн хүрээнд суралцахуйн үр дүнг боловсруулахдаа дээрх зөрүүг нөхөх зарчмыг баримтлахын зэрэгцээ хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэндийн боловсролын чиглэлээр хүүхэд өсвөр үеийнхний нас, сэтгэл зүйн онцлогт тулгуурласан болно.

Дээрх зүйлийг жишээний хамтаар дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 1.

Одоогийн нөхцөл байдал	Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал	Илэрсэн зөрүү	Мэдлэг, чадвар, хандлагын улмаас үүссэн зөрүү	Суралцахуйн үр дүн
Одоо юу болж байна вэ? /одоо ямар байна вэ?	Юу болох ёстой вэ? /ямар байх ёстой вэ?	Ямар байгаа болон ямар байх ёстой хоёрын зөрүү, ялгаа нь юу вэ?	Та одоогийн нөхцөл байдлыг ямар учраас байгаа гэж боддог вэ?	Хичээлийн үйл ажиллагаанд оролцсоны үр дүнд сурагчид юу чаддаг болсон байхыг та хүсэж байна вэ?
Сурагчид шүдний бүтэц, шүд болон гараа хэрхэн зөв угаах талаар хүүхдүүд цэцэрлэгт эзэмшсэн байдаг боловч сургуульд ороод энэ нь төдийлөн дадал хэвшил болоогүй байдаг.	Сурагчид шүдний бүтцийг зураг дээр тайлбарлах, шүд болон гараа хэрхэн зөв угаах дарааллын дагуу угааж чаддаг байх	Сурагчид шүдээ зөв угаахын тулд шүдний бүтэц, шүд болон гараа угаах дараалал ба хэзээ угаахаа мэддэггүй	М:Сурагчид шүдний бүтэц үүргийг шүд болон гар угаах аргачлалын ач холбогдлыг мэддэггүй Ч:Хэзээ хэрхэн шүд болон гараа угаах талаар дадал эзэмшээгүй Х:Сурагчид шүдээ өдөрт 2-3 удаагийн давтамжаар угаах болон гараа шаардлагатай тохиолдол бүрт аргачлалын дагуу зөв угаах дадлыг хэвшил болгоогүй.	Сурагч шүдний бүтцийг зураг дээр тайлбарлаж, шүд болон гараа шаардлагатай тохиолдолд аргачлалын дагуу зөв угаах дадлыг тайлбарлан таниулдаг болно.
Сурагчид бэлгийн ариун цэвэр сахиx биеэ цэвэр байлгах, эрүүл орчин бүрдүүлэх талаар хичээл дээр үзсэн ч өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх дадал хэвшил дунд зэрэг.	Сурагчид бэлгийн ариун цэвэр, эрүүл орчныг бүрдүүлэхийн ач холбогдлыг тайлбарладаг	Сурагчид бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм сахиx түүний бие махбодод үзүүлэх эерэг нөлөөллийг эрүүл орчинтой холбон тайлбарлаж чаддаггүй	М:Сурагчид бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг амьдралдаа хэрэгжүүлэхийн давуу болон сул талыг ойлгож мэддэггүй Ч:Бэлгийн ариун цэврийг сахиx өөрийн амьдарч буй орчны /анги танхим, гэрийн доторх болон гадна орчны/ ариун цэврийн талаар санаа бодлоо илэрхийлдэггүй Х: Хувийн болон орчны ариун цэврийг сахиx, бусдад шаардлага тавих, уриалах, төлөөлөл болж чаддаггүй	Сурагч бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхийн давуу талыг тайлбарладаг болно.

Үнэлгээний шалгуурыг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

- ✓ Нэгж хичээлийг судалснаар сурагчдад бодитой ямар өөрчлөлт гарахыг тооцоолох
- ✓ Багш тухайн өөрчлөлтийг хэрхэн үнэлэхээ тодорхойлох
- ✓ Бодит чадварын үнэлгээг орхигдуулахгүй байхад анхаарах
- ✓ Агуулга, үйл явц, чанар, үр нөлөөг үнэлэхэд чиглэгдсэн байх

Гүйцэтгэлийн 4 түвшнийг боловсруулахдаа дараах зарчимд тулгуурласан. Үүнд:

- ✓ Гүйцэтгэлийн түвшин тус бүр нь сурагчдын бодит байдлыг үнэлэх боломжтой байх ба оноожуулах боломжтой байх
- ✓ Цогц байх буюу гүйцэтгэлийн чанарын талаар дүгнэлт хийх боломжтой байх
- ✓ Үнэлгээний шалгуурт суурилсан байх буюу түүний цар хүрээнээс хэтрэхгүй байх

Нотолгоо буюу суралцахуйн үр дүнгийн шалгуурын дагуу үнэлгээ хийсэн баримт мэдээлэл

4 дүгээр ангийн “Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд” нэгжийн хүрээн дэх суралцахуйн үр дүнгийн шалгуур тус бүрийн хүрээнд дараах зүйлсийг нотолгоо болгоно.

<p>Суралцахуйн үр дүнгийн шалгуур 1: Сурагч шүдний бүтцийг зураг дээр тайлбарлаж, шүд болон гараа шаардлагатай тохиолдолд аргачлалын дагуу зөв угаах дадлыг тайлбарлан таниулдаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдлэг, чадварыг үнэлэх асуултын хуудас, түүнийг үнэлсэн рубрик • Бүтээлийн санг рубрикээр үнэлсэн үнэлгээний хуудас • Ажиглалтын үнэлгээний хуудас, түүнд оноо өгсөн үнэлгээний хуудас • Хандлагын үнэлгээний хуудас, түүнд оноо өгсөн багшийн бүртгэл
<p>Суралцахуйн үр дүнгийн шалгуур 2: Сурагч бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг сахихын ач холбогдлыг бусдад тайлбарладаг.</p>	<ul style="list-style-type: none"> • Дасгал ажлын хуудас, үнэлгээ өгсөн баримт • Бүтээлийн санг рубрикээр үнэлсэн хуудас • Хандлагын үнэлгээний хуудас, түүнд оноо өгсөн багшийн бүртгэл • Ярилцлагын хуудас болон ярилцлагын тэмдэглэл

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

2.1. СОНГОХ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ, АРГАЧЛАЛ

Үнэлгээний даалгавар 1. Сорил бөглөх

Үнэлгээний даалгаврын зорилго:	Шүдний бүтэц үүрэг, шүдний буруу ургалтаас сэргийлэх, шүдээ арчлах аргын талаар сурагчдын эзэмшсэн мэдлэг, хандлагыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Гарааны, явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Сонгох
Нотлох баримт:	Сурагчийн бөглөсөн тестийн хуудас, үнэлгээ өгсөн хуудас
Гүйцэтгэх хугацаа:	35-40 минут

Дараах сорилыг сурагчдад тараан өгч бөглүүлнэ.

Сорилын хуудас

Сурагчийн нэр: _____

Он сар өдөр: _____

Заавар: Дараах асуулт тус бүрийг анхааралтай уншаад, өөрийн сонгосон хариултын өмнөх үсэг эсвэл тоог дугуйлна уу.

- Байнгын ба сүүн шүдний дотоод бүтцийг сонгоно уу. (1 оноо)
 - Цөгц, сурвалж, хүзүү
 - Паалан, тугалмай, зөөлц**
 - Зөөлц, холбоос эд, тулгуур эд
- Шүдний амны хөндийд байрших зөв дарааллыг сонгоно уу. (1 оноо)
 - Үүдэн шүд, бага араа, соёо шүд, их араа
 - Соёо шүд, үүдэн шүд, бага араа, их араа
 - Үүдэн шүд, соёо шүд, бага араа шүд, их араа**
 - Бага араа, соёо шүд, үүдэн шүд, их араа
 - Их араа, соёо шүд, бага араа, үүдэн шүд
- Хүснэгтэд шүд буруу ургахад нөлөөлдөг зуршлуудаас тохирох хариултыг сонгож тэмдэглэнэ үү. (3 оноо)

№	Өгөгдөл	Тийм	Үгүй
1.	Чихэрлэг хоол хүнс ихээр хэрэглэх		-
2.	Үзэг балаа байнга амандаа хийх	+	
3.	Шүдийг аргачлалын дагуу угаахгүй байх		-
4.	Хурц үзүүртэй зүйлээр шүдээ цэвэрлэх	+	
5.	Шинээр ургаж буй шүдээ хэлээрээ оролдох, шүдээ зуух	+	
6.	Хуруугаа байнга хөхөх	+	
7.	Шүд цооролтыг хайхрахгүй байснаар эрт шүдээ авахуулах		-
8.	Хатуу үстэй шүдний сойз хэрэглэх		-
9.	Хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил хоцрогдох		-

4. Аль нь зөв бэ? Дараах зургуудыг анхааралтай ажиглаад зөв хариултыг дугуйлна уу. (1 оноо)

1.  А.  Б.

2.  А.  Б.

3.  А.  Б.

А. 1А 2Б 3Б Б. 1Б 2А 3А **В. 1А 2Б 3А**

5. Шүд цоорох болон амны хөндийн бусад өвчнөөс сэргийлэх хамгийн найдвартай арга юу вэ? (1 оноо)

- А. Сойзоо зөв байрлуулж шүдээ сайтар угаах
 Б. Шүдний эмчид тогтмол үзүүлж эмчилгээ хийлгэх
 В. Хоолны дэглэм сахих

6. Шүдний гажиг гэж юу вэ? (1 оноо)

- А. Шүд бага зэрэг муруй ургасныг хэлнэ.
 Б. Шүд зөв хэлбэртэй ургахгүй байхыг хэлнэ.
 В. Шүдний хэлбэр өөрчлөгдөж ургахыг хэлнэ.

7. Гар угаах дарааллын зөв хувилбарыг сонгоно уу. (1оноо)

1. Крантаа хаах 2. Гараа чийглэх 3. Гараа хөөсөртөл савандах
 4. Гараа арчих 5. Гараа үрэх 6. Гарын саванг арилгах

а. 1.3.6.5.4.2 б. 1.3.6.4.5.2 в. 3.4.6.5.2.1 **г. 2.3.5.6.1.4**

8. Эмэгтэй хүн бэлгэ эрхтнийг угаахдаа ямар чиглэлээр угаах вэ? (1 оноо)

- А. Хойноос нь урагшаа чиглэлд угаана.
 Б. Урдаас нь хойш нь чиглэлд угаана.

9. Өгөгдлийг уншаад үнэн худлыг тодорхойлно уу. (3 оноо)

№	Өгөгдөл	Үнэн	Худал
1.	Халдварт өвчин бохир гараар дамжин халдварладаг.	+	
2.	Гараа зөв угааж хэвших нь эрүүл мэндээ хамгаалах чухал арга мөн.	+	
3.	Шүдээ аргачлалын дагуу зөв угааж хэвших нь эрүүл мэндэд төдийлөн ач холбогдолгүй.		-
4.	Бэлгийн ариун цэвэр эрүүл ахуйн дэглэмийг сахих нь эрүүл мэндэд чухал ач холбогдолтой.	+	
5.	Бэлгэ эрхтний ариун цэвэр сахих нь зөвхөн охидод хамаатай асуудал.		-
6.	Бэлгийн бойжилтын үед бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг баримтлах нь эрүүл мэнд, гоо зүйд нөлөөлдөггүй.		-
7.	Шилжилтийн насанд биеийн жин, өндөрт өөрчлөлт гарахгүй.		-
8.	Бэлгийн бойжилтын үед охид хөвгүүдийн бие махбодод олон өөрчлөлт гардаг.	+	
9.	Охид, хөвгүүд бэлгэ эрхтнээ хойноос нь урагшаа чиглэлээр бүлээн усаар угаах ёстой.		-

10. Шүдний хэлбэр болон гүйцэтгэх үүргийг зөв харгалзуулж, тохирох хариултыг сонгож дугуйлна уу. (1 оноо)

- | | |
|--------------|--|
| 1. Үүдэн шүд | А. Хоол хүнсийг зулгаах үүрэгтэй. |
| 2. Соёо шүд | Б. Цүүц хэлбэртэй, хурц ирмэгтэй, хоол хүнсийг таслах үүрэгтэй. |
| 3. Араа шүд | В. Зажлах үйлийг гүйцэтгэхэд зохицсон дөш хэлбэртэй, хоол хүнсийг жижиглэх, бутлах үүрэгтэй. |

а. 1.Б, 2.А, 3.В б. 1.А, 2.Б, 3.В в. 3.А, 2.В, 3.Б

2.2. ЗАДГАЙ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ, АРГАЧЛАЛ

Үнэлгээний даалгавар 1. Нөхөх болон хариулж бичих даалгавар

Үнэлгээний даалгаврын зорилго:	Харилцааны хэлбэр болон харилцаанд нөлөөлөх зүйлс, бусдад анхаарал халамж тавих зэргийг тодорхойлж чадаж байгаа эсэхийг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Гарааны, явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Сурагчийн бөглөсөн тестийн хуудас, үнэлгээ өгсөн хуудас
Гүйцэтгэх хугацаа:	30 - 40 минут

1. Цэгийн оронд тохирох үгийг сонгон, нөхөж бичээрэй. (дарааллын дагуу, арга, зөв угаах, гараа) (2 оноо)

..... тогтмол угаах нь халдварт өвчнөөс сэргийлэх энгийн юм.

2. Зурагт өгөгдсөн дарааллын дагуу цэгийн оронд гар угаах аргачлалыг нөхөж бичнэ үү. (4 оноо)



- | |
|----------|
| 1. _____ |
| 2. _____ |
| 3. _____ |
| 4. _____ |
| 5. _____ |
| 6. _____ |
| 7. _____ |
| 8. _____ |

3. Цэгийн оронд тохирох үгийг сонгон, нөхөж бичээрэй. (хүүхэд, том хүн болох, өсвөр үе) (3 оноо)
Шилжилтийн нас гэж хүүхэд наснаас аажмаар нас бие гүйцэж үеийг хэлнэ. Бэлгийн бойжилт нь шилжилтийн насанд явагдах хэвийн үйл явц бөгөөд хүн бүрт тохиолддог.

4. Охидын бэлгийн бойжилтын үед бие махбодод гарах бусад шинжийг жагсааж бичээрэй.

- А. Биеийн өндөр, жин нэмэгдэх
- Б. _____
- В. _____
- Г. _____
- Д. _____
- Е. _____

Зөв хариулт: (биеийн өндөр, жин нэмэгдэх, батга гарах, бэлгэ эрхтэн орчимд болон суганд үс ургах, хөлрөх, нүүр царайны хэлбэр төрх өөрчлөгдөх, биений юм ирэх)

Багшийн анхаарах зүйл: Үнэлгээний даалгавар сурагчдын мэдлэг, ойлголтын түвшнийг илрүүлж чадаж байна уу, үгүй юу гэдгийг багшлах арга зүйн үүднээс анзаараарай.

- ✓ Сонгох даалгаврыг 1-1,5 минутад гүйцэтгэх ба ихэвчлэн 1 оноо авахаар хийгддэг.
- ✓ Олон сонголттой даалгаврыг үнэлгээнд ойлгох, мэдлэгээ бодит нөхцөлд хэрэглэх, дүн шинжилгээ хийх, үнэлэх, сэргээн санах чадваруудыг сориход голлон хэрэглэдэг.

5. Дараах алхмын дагуу хийж гүйцэтгээд, алхам тус бүрийн хариултыг 1-3 оноо өгч үнэлээрэй. (3 оноо)

Алхам 1. Амны хөндийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж болох зан үйлийг өгөгдсөн зурагнаас сайтар ажиглаж, буруу зөв эсэхийг тодорхойлоорой.

Алхам 2. Өөрчилж болох зан үйлийн жагсаалтыг нөхөж бичээрэй.

Алхам 3. Хэрэгжүүлж болох нэг жагсаалтыг сонгож, өөрийнхөө санал бодлыг тайлбарлаарай.

	Зан үйлүүд	Зан үйлийг өөрчлөх хувилбарууд
А.		<p>Алхам 1. Энэ зан үйл нь зөв үү, буруу юу? Яагаад?</p> <p>_____</p> <p>Алхам 2. Буруу бол үүнийг өөрчилж болохоор зан үйлийн жагсаалт гаргана уу.</p> <p>_____</p> <p>Алхам 3. Хэрэгжүүлж болох нэг зүйлсийг сонгож, өөрийнхөө санал бодлыг тайлбарлаарай.</p> <p>_____</p>
Б.		<p>Алхам 1. Энэ зан үйл нь зөв үү, буруу юу? Яагаад?</p> <p>_____</p> <p>Алхам 2. Буруу бол үүнийг өөрчилж болохоор зан үйлийн жагсаалт гаргана уу.</p> <p>_____</p> <p>Алхам 3. Хэрэгжүүлж болох нэг зүйлсийг сонгож, өөрийнхөө санал бодлыг тайлбарлаарай.</p> <p>_____</p>

В.		<p>Алхам 1. Энэ зан үйл нь зөв үү, буруу юу? Яагаад?</p> <p>_____</p> <p>Алхам 2. Буруу бол үүнийг өөрчилж болохоор зан үйлийн жагсаалт гаргана уу.</p> <p>_____</p> <p>Алхам 3. Хэрэгжүүлж болох нэг зүйлсийг сонгож, өөрийнхөө санал бодлыг тайлбарлаарай.</p> <p>_____</p>
Г.		<p>Алхам 1. Энэ зан үйл нь зөв үү, буруу юу? Яагаад?</p> <p>_____</p> <p>Алхам 2. Буруу бол үүнийг өөрчилж болохоор зан үйлийн жагсаалт гаргана уу.</p> <p>_____</p> <p>Алхам 3. Хэрэгжүүлж болох нэг зүйлсийг сонгож, өөрийнхөө санал бодлыг тайлбарлаарай.</p> <p>_____</p>

Зөв хариултын хувилбарууд:

Хариулт	Хариултын тайлбар	1-3 оноо
А	Гараараа шүдээ оролдох нь шүдний гаж буруу хөгжилд нөлөөлдөг.	
Б	Үзэг, харандаа, бал зэрэг хатуу зүйлийг амандаа хийх нь шүдний буруу ургалтад нөлөөлдөг хүчин зүйлийн нэг юм.	
В	Чихэр их идсэнээс болж шүд цоорч, шүд өвдөж авахуулахад хүрч болзошгүй.	
Г	Шүдээрээ ундааны тагийг онгойлгох зэргээр шүдийг гэмтээх, мөн шүдний буруу ургалтад нөлөөлдөг.	

Үнэлгээний даалгавар 2. Бүтээлийн сан

Үнэлгээний даалгаврын зорилго:	Амны хөндийн эрүүл ахуй болон шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замын талаарх мэдлэг, чадвар аргачлалын дагуу шүдээ зөв угаах дарааллыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж байгаа эсэх хандлагыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Өгсөн удирдамжийн дагуу зохиосон өгүүллэг, түүнд өгсөн үнэлгээний хуудас
Гүйцэтгэх хугацаа:	1 долоо хоног

“Шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга” сэдвийн хүрээнд өгүүллэг бичиж зураг зурах удирдамж

Заавар: Жишээгээр өгсөн өгүүллэгийг уншаад доторх агуулгын хүрээнд сайтар бодож, өөрийн санаа бодлоо илэрхийлэн цааш нь үргэлжлүүлэн өгүүллэг зохиож бичнэ.

- ✓ Сурагчид эхлээд өгүүллэг зохиож, дараа нь өгүүллэгийнхээ агуулгаар зураг зурна.
- ✓ Зурсан зургаараа зурагт хуудас гаргаж бүтээлээ үнэлүүлнэ.

Жишээ болгон өгсөн өгүүллэг: /хэвлэж өгөх хувилбар/

Надад хамаагүй

Шүд арчлах нь цагийн гарз хэмээн боддог нэгэн жаалхүүгийн тухай энд өгүүлье.

- Чиний шүд шарлаж бохирдсон байна.
- Тэгээд юу гэж?
- Буйлнаас чинь цус гарч байна.
- Гарч л байг...

*Өгүүллэгийг цааш нь гүйцээгээрэй.
Хүү яаж шүдээ арчилдаг болсон бэ?*

Болохоо больсон шүд

Маш бөх бөгөөд ажилсаг нэгэн шүдний тухай өгүүллэг.

Тэр өөртэйгээ ийнхүү ярьж гэнэ. Чихэртэй ундаа над руу цутгаж, хорхойд идүүлэхээс өмнө их сайхан байж дээ. Одоо ч бөөн нянгууд над дээр гарч үүрлэхээр дайрдаг боллоо...

Цааш нь үргэлжлүүлээрэй.

Бүтээлийн санг үнэлэхдээ үнэлгээний зорилгоо мэдэх нь чухал. Багш тус даалгаврын гүйцэтгэлээр дараах зүйлсийг мэдэх боломжтой. Үүнд:

- Шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замын талаар мэддэг болсон эсэх

Тухайлбал: Сурагчид багаар ажиллах явцдаа өгүүллэгийг үргэлжлүүлэн зохиож буй байдал болон өгүүллэгийг зургаар хэрхэн илэрхийлсэн байдлаар шүдээ арчлах, шүдэнд халтай хүнсний бүтээгдэхүүнийг нэрлэх, мөн амны хөндийн эрүүл ахуйн дэглэм сахихын ач холбогдлын талаарх мэдлэгийг үнэлж дүгнэх боломжтой.

- Аргачлалын дагуу шүдээ зөв угаах дадал, хандлага бий болсон эсэх

Тухайлбал: Сурагчид багаар ажиллах явцдаа өгүүллэгт амны хөндийн ариун цэврийг сахихын ач холбогдол, сахиагүйн сөрөг үр дагаврыг өөрсдийн үгээр тоочин бичиж, өгүүллэгийн агуулгыг зургаар илэрхийлж зурсан байдал, зурагт хуудас гаргаж бүтээлээ үнэлүүлж байгаа нь сурагчдад бүтээлч аргыг төлөвшүүлээд зогсохгүй тэд эзэмшсэн мэдлэг, чадвараа амьдрал дээр хэрэгжүүлэх хандлага ямар байна вэ гэдгийг үнэлэх боломж олгож байгаагаараа онцлог юм.

Дээрх зүйлийг үнэлэхдээ дараах рубрикийг ашиглана.

5 оноо	<ul style="list-style-type: none"> • Амны хөндийн эрүүл ахуйн дэглэмийг баримтлахын ач холбогдлыг тайлбарлан бичсэн бол • Аргачлалын дагуу шүдээ зөв угаахын ач холбогдлыг таниулан бичсэн, зурсан бол • Шүдээ зөв угаагаагүйгээс гарах сөрөг үр дагаврыг бичсэн, зургаар илэрхийлж зурсан бол • Шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудыг бусдад таниулж, зурагт хуудас гарган сурталчилсан бол
4 оноо	<ul style="list-style-type: none"> • Амны хөндийн эрүүл ахуйн дэглэмийн талаар тоочиж бичсэн бол • Аргачлалын дагуу шүдээ зөв угаахын ач холбогдлыг таниулан бичсэн, зурсан бол • Шүдээ зөв угаагаагүйгээс гарах сөрөг үр дагаврыг тоочин бичиж, зургаар илэрхийлсэн бол • Шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудыг нэрлэж, зургаар илэрхийлсэн бол
3 оноо	<ul style="list-style-type: none"> • Аргачлалын дагуу шүдээ зөв угаахын ач холбогдлыг тайлбарлан бичсэн бол • Шүдээ зөв угаагаагүйгээс гарах сөрөг үр дагаврыг зураг дээр тайлбарласан бол
2 оноо	<ul style="list-style-type: none"> • Аргачлалын дагуу шүдээ зөв угаахын ач холбогдлыг тоочиж бичсэн бол • Шүдээ угаагаагүйгээс гарах сөрөг үр дагаврыг нэрлэж, зургаар илэрхийлэхийг оролдсон бол
1 оноо	<ul style="list-style-type: none"> • Шүдээ угаах, арчлахын ач холбогдлоос тоочиж бичсэн бол • Шүдэнд халтай хүнсний бүтээгдэхүүнүүдийг нэрлэж, зургаар илэрхийлсэн бол

Бүтээлийн сангийн нийт авах оноо 5-25 юм. Үүнийг дараах байдлаар түвшинчилж сурагчдыг үнэлж болно.

- Хангалтгүй 5-9 оноо
- Дунд зэрэг 10-14 оноо
- Хангалттай 15-19 оноо
- Хангалттай сайн 20-25 оноо

Багшийн анхаарах зүйл: Бүтээлийн санд өгүүллэгийг хэрхэн яаж бичих удирдамж, жишээнүүд, үнэлгээний рубрикийг танилцуулж, шаардлагатай бол хэвлэмэл хувилбарыг тарааж өгнө.

- ✓ Сурагчдын хийсэн бүтээлийг бүтээлийн сандаа хадгалж, бусдад туршлагыг нь түгээн дэлгэрүүлж болно.
- ✓ Үнэлгээнд бүтээлийн санг ашиглах нь сурагчдад бүтээлч аргыг төлөвшүүлэх чухал ач холбогдолтой.

Үнэлгээний даалгавар 3. Ажиглалтын арга

Үнэлгээний даалгаврын зорилго:	Шүдний бүтэц, үүрэг, буруу ургалт, шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудын талаарх мэдлэг, аргачлалын дагуу шүдээ зөв угаах дарааллыг өдөр тутмын амьралдаа хэрэгжүүлж байгаа эсэх дадал, хандлагыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Нэгж хичээлийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Ажиглалт, туршилт, үнэлгээ хийсэн ажлын хуудаснууд, түүнд өгсөн үнэлгээний хуудас
Гүйцэтгэх хугацаа:	1 долоо хоног

“Шүдний буруу ургалтаас сэргийлэх, шүдээ арчлах арга” сэдвийн хүрээнд ажиглалт хийх удирдамж

Заавар: Ажиглалт нь судлагдахууныг мэдрэхүйн эрхтнээр дамжуулан хүлээн авч тэмдэглэл хөтлөн, сонирхсон мэдээллээ цуглуулж, дүн шинжилгээ, дүгнэлт хийх үйл ажиллагаа юм. Тус ажиглалтыг хийхдээ:

- ✓ Ажиглалтын хуудас-1 дээр өгөгдсөн хүснэгт дэх чиглэлийн дагуу сурагчид янз бүрийн насны хүмүүсийн шүдний бүтцийг ажиглан, тайлбар хэсэгт өөрийн дүгнэлтийг бичнэ.
- ✓ Ажиглалтын хуудас-2 дээр өгөгдсөн зургийн дагуу өсвөр насны хүүхдийн амны хөндийн бохирдлыг ажиглах туршилт хийж, дадал хандлагыг үнэлнэ.

АЖИГЛАЛТЫН ХУУДАС 1.

Огноо: _____ Анги бүлэг _____ Ажиглагчийн нэр _____

Судалгааны нэр: _____

Ажиглалтын талаарх тэмдэглэл: _____

№	Ажиглалтад оролцох хүмүүс	Шүдний тоо	Хар ба шар толботой шүд	Цоорсон шүд	Ломботой шүд	Шүд нь унасан	Шүдний гажиг	Тайлбар
1	Нялх хүүхэд							
2	Дүү нар							
3	Ах, эгч							
4	Насанд хүрэгсэд							

5	Эмээ, өвөө						
6	Өөрийн						
7	Найз нөхөд						

АЖИГЛАЛТЫН ХУУДАС 2.

Огноо: _____ Анги бүлэг _____ Ажиглагчийн нэр _____

Судалгааны нэр: _____

Ажиглалтын талаарх тэмдэглэл: _____

Ажиглаад туршаад үзээрэй.



Хүүхдүүд шүдээ угаахдаа шилэн аяганд ус хийж, сойзоо дүрэн шүдийг цэвэрлэснээр шүд, амны хөндийн бохирдлыг ажиглах, хянах нь хүүхдэд ойлгуулах сайн арга болдог.

Ажиглалтыг дараах байдлаар оноожуулан үнэлж болно.

Оноожуулах аргачлал:

Үнэлэх зүйл	Оноо
Алхам 1. Сурагч шүд амны хөндийн бохирдлыг ажиглах	
Холбогдох мэдээллийг бүрэн гүйцэд өгсөн байвал	5 оноо
Холбогдох мэдээллийг багтаасан байвал	3 оноо
Бага мэдээлэл, тайлбар оруулсан товч байвал	2 оноо
Нийт	5 оноо
Алхам 2. Сурагч янз бүрийн насны хүмүүсийн шүдний бүтцийг ажиглах	
Ажиглалтын зорилго – Бүх насны хүмүүсийг хамруулсан бол	1-2 оноо
Мэдээлэл нь тухайн насныханд хамааралтай, ойлгомжтой, зөв байвал	1-3 оноо
Тухайн насныханд тохирсон үнэн, зөв зөвлөмж бичсэн бол	1-5 оноо
Нийт	10 оноо
Алхам 3. Эргэцүүлэл хийх	
Дадал хэвшил бий болгосон бол (3 оноо)	3 оноо
Дадал хэвшил бий болгохоор шийдсэн бол (2 оноо)	2 оноо
Нийт	3 оноо
БҮГД	18 оноо

Ажиглалтын аргаар үнэлгээний даалгаврыг гүйцэтгэснээр 7-18 оноо авах боломжтой. Тус оноог дараах байдлаар түвшинчлэн сурагчийг үнэлнэ.

- Хангалтгүй 7-9 оноо
- Дунд зэрэг 10-12 оноо
- Хангалттай 13-15 оноо
- Хангалттай сайн 16-18 оноо

Багшийн анхаарах зүйл: Ажиглалтын аргыг үнэлгээнд хэрэглэхдээ.

- ✓ Хүүхдүүдэд ажиглалтаа баримтжуулахын тулд ажиглалтын хуудсаа бөглөхийг сануулаарай.
- ✓ Сурагчдын хандлагыг анзаарахдаа тэдний гаргаж буй алдааг харгалзан үнэлээрэй.

Үнэлгээний даалгавар 4. Сорил туршилт

Үнэлгээний даалгаврын зорилго:	Шүдний өнгөр болон түүнээс үүдсэн шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудын талаарх мэдлэг, аргачлалын дагуу шүдээ зөв угаах дарааллыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж байгаа эсэх дадал, хандлагыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Ээлжит хичээлийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Сорил туршилт, үнэлгээ хийсэн ажлын хуудаснууд, түүнд өгсөн үнэлгээний хуудас
Гүйцэтгэх хугацаа:	40 минут

*“Шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх, шүдээ арчлах арга”
сэдвийн хүрээнд ажиглалт хийх удирдамж*

Заавар: Сурагчид хос хосоороо болж “Шүдний өнгөр түүнийг хянах” туршилтыг хийнэ.

Туршилт хийх аргачлал:

- ✓ Хосууд хүнсний будгаар шүдээ будна. Хүнсний будгийг чих ухдаг үзүүртээ хөвөнтэй модоор шүдэндээ түрхэнэ. /туршилтын дараа толбыг шүдний сойзоор арилгана/
- ✓ Дараа нь толинд харж, бие биенийхээ шүдийг ажиглаж хаана хамгийн их толбо болсныг олж тогтооно. Өнгөр хамгийн их тогтсон хэсэгт толбо их тогтдог.
- ✓ Туршилтын үр дүнг үнэлж, дүн шинжилгээ хийнэ.

АЖИГЛАЛТЫН ХУУДАС 1.

Огноо: _____ Анги бүлэг _____ Ажиглагчийн нэр _____

Судалгааны нэр: _____

Ажиглалтын талаарх тэмдэглэл: _____

Зураг авсан эсэх _____ тийм _____ үгүй _____



1. Аль шүдэнд хүрэхэд хамгийн их төвөгтэй байсан бэ?
2. Харилцан бие биенийхээ шүдийг харж ажиглаад тэмдэглээрэй.
3. Өнгөрийг арилгах хамгийн сайн аргыг нэрлэнэ үү.

Хариулт:

- 1 _____
- 2 _____
- 3 _____

Өөрийн үнэлгээний хуудсыг сурагчдад өгч бөглүүлнэ. Тухайн өөрийн үнэлгээг хийхдээ бодитой үнэлэхийг сурагчдад анхааруулна.

ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сургууль: _____ Анги: _____

Хичээлийн нэр: _____

Судалсан сэдвийн нэр: _____

Сурагчийн нэр: _____ Он сар өдөр: _____

Заавар: Дараах өгөгдөл тус бүрийг анхааралтай уншаад, үндсэн 3 чиглэлийн дагуу өөрт тохирох хариултыг сонгож, ✓ тэмдэглэгээ хийнэ.

Шалгуур	Тухайн зүйлийн талаар хэр зэрэг түвшинд ойлголт мэдлэгтэй болсон гэж үзэж байна вэ?	Үүнийг бодит нөхцөлд хэрэглэх чадварыг ямар түвшинд эзэмшсэн гэж үзэж байна вэ?	Таны хувьд тухайн зүйлийн талаар нэмж судлах шаардлагатай гэж үзэж байна уу?
1. Шүдний цоорлоос сэргийлэх дадал хэвшлээс өөртөө хэрэгжүүлэх	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
2. Шүдний өнгөрийг ажиглаж хянах нь өөрийн эрүүл мэндэд хийж буй чухал алхам учраас дадал болгож хэвшүүлэх	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3. Шүдний цоорлоос сэргийлэх талаар бусдад зөвлөх	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

Оноожуулах аргачлал:

Өөрийн үнэлгээний хуудаст байгаа түвшинчилсэн утгыг маш сайн – 3 оноо, дунд зэрэг – 2 оноо, тааруухан – 1 гэсэн байдлаар оноожуулна.

Харин нэмж судлах хэрэгтэй эсэхийг илэрхийлсэн хариултад оноо өгөх шаардлагагүй. Тиймээс өгөгдөл тус бүрээр 2 асуултын хариултын оноог нэмж нийлбэр оноог гаргана. Сурагчийн нийт авах оноо 6 – 18 оноо байна. Тус оноог дараах байдлаар түвшинчлэн ашиглаж болно.

- Хангалтгүй 6 – 9 оноо
- Дунд зэрэг 10 – 12 оноо
- Хангалттай 13 – 15 оноо
- Хангалттай сайн 16 – 18 оноо

Багшийн анхаарах зүйл: Зарим хүүхдийн хувьд энэ арга болж байхад өөр хүүхдэд бас нэг арга зам илүү таалагдах жишээтэй.

- ✓ Сорил туршилтын аргыг ээлжит хичээлийн үнэлгээнд ашиглах нь илүү үр дүнтэй байж болно.
- ✓ Сурагчдад шүдээ дутуу угааж, сайн цэвэрлэдэггүй хэсгүүдэд шүдний өнгөр их хэмжээгээр хуримтлагддаг ба тод будагддаг гэдгийг сайтар тайлбарлаж өгөөрэй.
- ✓ Янз бүрийн бодист эмзэг, харшилтай хүүхэд байгаа эсэхийг асууж, хэрвээ тийм хүүхэд байвал туршилтад оруулахгүй байх
- ✓ Хичээлийн дараа бие биедээ нэр хоч өгөхгүй байх талаар сануулах хэрэгтэй.

Үнэлгээний даалгавар 5. Асуулт хариулт / Ярилцлага

Үнэлгээний даалгаврын зорилго:	Бэлгийн ариун цэвэр, хувийн эрүүл ахуйн дэглэмийг сахихын ач холбогдлын талаарх мэдлэг, бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг өдөр тутмын амьралдаа хэрэгжүүлж байгаа эсэх дадал, хандлагыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Гарааны, явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Ярилцлага тэмдэглэсэн хуудас, түүнд өгсөн үнэлгээний хуудас
Гүйцэтгэх хугацаа:	40 минут

*“Бэлгийн ариун цэвэр, хувийн эрүүл ахуйн дэглэм” сэдвийн хүрээнд
хийх ярилцлагын удирдамж*

Заавар: Сурагчид бэлгийн ариун цэвэр, хувийн эрүүл ахуйн дэглэмийг сахихын ач холбогдлын талаар ярилцаж, тэмдэглэл хөтөлж болно. Тус ярилцлагаар:

- ✓ Нээлттэй хариулт бүхий урьдчилан бэлтгэсэн сэдвийн дагуу ярилцлага зохионо.
- ✓ Урьдчилан бэлтгэсэн асуулт нь гол төлөв оролцогчийн итгэл үнэмшил, хандлагыг үнэлнэ.

Ярилцлагын үр дүнг үнэлж, дүгнээд багш цаашид өсвөр насныхны дунд зохиох үйл ажиллагааны урт ба богино хугацааны төлөвлөгөөг гарган ажиллах боломжтой.

ЯРИЛЦЛАГА ТЭМДЭГЛЭХ ХУУДАС

Таны нас _____

Таны хүйс _____

№	Асуулт	Хариулт
1	- Та бэлгийн бойжилт буюу шилжилтийн насны талаар нээлттэй ярилцахад бэлэн байна уу? Үгүй бол яагаад? - Шилжилтийн насанд өсвөр үеийнхэнд ямар бэрхшээл учирдаг вэ? Амьдрал дээрх бодит жишээ, кейс дээр өөрийн санаа, бодлоо тайлбарлана уу.	Ярилцлагыг энд тэмдэглэнэ үү.
2	Шилжилтийн насанд охид, хөвгүүдийн бие махбодод ямар өөрчлөлтүүд гардаг вэ? Энэ үед мөрдөх эрүүл ахуйн дэглэмээс тоочиж нэрлэнэ үү.	Ярилцлагыг энд тэмдэглэнэ үү.
3	Бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөөгүйгээс ямар сөрөг үр дагавар гарах вэ?	Ярилцлагыг энд тэмдэглэнэ үү.
4	Бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөж хэрэгжүүлсний давуу болон сул талыг харьцуулан тайлбарлана уу.	Ярилцлагыг энд тэмдэглэнэ үү.
5	Ярилцлагын дараа таны мэдлэг, чадвар, хандлагад өөрчлөлт гарах уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй 4. Хариулахгүй

Дараах хүснэгт дэх өгөгдөл тус бүрийг анхааралтай уншаад, өөрийн санал бодлыг илэрхийлэх хариултыг сонгож, түүнд харгалзах тоог дугуйлна уу. Үүнд:

Бүрэн санал нийлнэ – 5, Санал нийлнэ – 4, Эргэлзэж байна – 3, Санал нийлэхгүй – 2, Огт санал нийлэхгүй – 1

№	Өгөгдөл	Хариулт				
		5	4	3	2	1
1	Бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийн талаар заавал хэн нэгнээс асуух шаардлагагүй.	5	4	3	2	1
2	Шилжилтийн насны үед бие махбод болон сэтгэл санаанд гарах өөрчлөлтүүдийн талаар судлах хэрэгтэй.	5	4	3	2	1
3	Бэлгийн бойжилт нь шилжилтийн насанд явагдах хэвийн үйл явц бөгөөд хүн бүрт тохиолддог учраас санаа зовох хэрэггүй.	5	4	3	2	1
4	Бэлгэ эрхтний ариун цэвэр сахих нь зөвхөн охидод хамаатай асуудал биш хөвгүүдэд ч бас хамаатай.	5	4	3	2	1
5	Ярилцлагын дараа таны мэдлэг, чадвар, хандлагад өөрчлөлт гарна.	5	4	3	2	1

Ярилцлага нь бэлгийн ариун цэвэр, хувийн эрүүл ахуйн дэглэмийг сахихын ач холбогдлын талаар хандлагыг үнэлэхэд чиглэгдсэн болно. Хандлагын асуултыг шууд зөв буруу гэж үнэлэх боломжгүй ч тус сэдвийг судалснаар сурагчдад төлөвшүүлэхийг хүсэж буй хандлага ямар түвшинд байгааг үнэлж дүгнэлт хийнэ. Тус хандлагын асуултын хүрээнд сурагчид дараах оноо авах сонголтыг хийсэн бол бидний зорилго биелэгдсэн буюу хичээлийн үр дүн гарсан гэж үзнэ.

- Өгөгдөл 1: 1-ийг сонговол 2 оноо; 2-ыг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 2: 5-ыг сонговол 2 оноо; 4-ийг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 3: 5-ыг сонговол 2 оноо; 4-ийг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 4: 5-ыг сонговол 2 оноо; 4-ийг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 5: 5-ыг сонговол 2 оноо; 4-ийг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй

Дээрх үнэлгээний сонгох даалгаврын гүйцэтгэснээр нийт 10 оноо авах ёстой ба сурагчийн авсан оноог дараах байдлаар түвшинчлэн үнэлгээ өгч болно.

- Хангалтгүй: 0-1 оноо
- Дунд зэрэг: 2-4 оноо
- Хангалттай: 5-7 оноо
- Хангалттай сайн: 8-10 оноо

Багшийн анхаарах зүйл:

- ✓ Ярилцлага нь нээлттэй, судалгааны зорилгоор баримт цуглуулж буй үйл ажиллагаа тул оролцогчдын хандлагын өөрчлөлтийг ажиглах
- ✓ Ярилцлагыг баримтжуулахын тулд ярилцлагын явцад оролцогчийн хэлсэн зүйлийг тэмдэглэх
- ✓ Тэмдэглэл хөтлөх үйл явцыг хурдавчлах зорилгоор тэмдэглэл хөтлөх хуудасны загвар гарган тэмдэглэх

Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Тус нэгжийн хүрээнд бид сонгох даалгаврын нийт 10 асуулт бүхий хувилбар, 5 төрлийн задгай даалгаврыг боловсруулсан. Эдгээрийг хэрхэн ашиглаж, дүн шинжилгээ хийх талаар авч үзье.

Сонгох даалгаврын эхний хувилбар нь зөвхөн “Шүдний бүтэц, үүрэг, шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга” сэдвийн хүрээг хамарсан бөгөөд мэдлэг, хандлагыг үнэлэхэд чиглэгдсэн. Үүнийг явцын үнэлгээнд ашиглахад маш тохиромжтой. Гарааны болон үр дүнгийн үнэлгээний даалгаврын нэг бүрэлдэхүүн хэсэг болгон ашиглах боломжтой.

Сонгох даалгаврын хувилбар нь “Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд” нэгжийг бүхэлд нь хамарсан боловч сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг өөрийн үнэлгээнд тулгуурлан үнэлэхэд түлхүү анхаарсан. Хандлагын төлөвшлийг харах боломжгүй. Тус үнэлгээг гарааны, явцын, үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой. Гэхдээ дараах байдлаар хэрэглэвэл тохиромжтой. Тухайлбал, гарааны үнэлгээ болон үр дүнгийн үнэлгээнд зэрэг ашиглах, эсвэл явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах гэсэн хувилбар байж болно. Харин гараа, явц, үр дүнгийн үнэлгээнд дараалуулан ашиглавал сурагчид залхах магадлалтай.

Хэрвээ гарааны үнэлгээнд ашигласан бол тус бүлэг сэдвийг судалсны дараа сурагч түүнийг дахин ашиглан, өөртөө дүн шинжилгээ хийх боломжтой. Эсвэл гарааны үнэлгээнд ашиглалгүй явцын үнэлгээнд ашиглаж, мөн дээрхийн адил жилийн эцэст үр дүнгийн үнэлгээ болгон ашиглах боломжтой. Өөрийн үнэлгээг дангаар нь дүн тавих үнэлгээ болгон ашиглах боломжгүй тул бусад үнэлгээтэй хамт хэрэглэж, дүн шинжилгээ хийх нь тохиромжтой. Сурагчийн өөрийн үнэлгээ бусад үнэлгээтэй хэр зэрэг нийцэж буйг багш харьцуулан дүн шинжилгээ хийх хэрэгтэй (Доор өгсөн хүснэгтээс харна уу).

Тус нэгжийн үнэлгээнд ашигласан үнэлгээний даалгаврын төрөл тус бүрээр авсан оноог ижил хэмжээст шилжүүлэн, дараах байдлаар нэгтгэн, сурагч тус бүрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж болно.

Үнэлгээний даалгаврын төрөл	Гүйцэтгэлийн шалгуур 1	Гүйцэтгэлийн шалгуур 2
Бүтээлийн сан	()	
Ажиглалт	()	
Сорил туршилт	()	
Асуулт хариулт/ Ярилцлага		()
Нийт оноо	()	()
Дундаж оноо	()	

Багш хичээлийн үр дүнг сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг танин мэдэхүйн эсвэл гүйцэтгэлийн түвшингээр нь харьцуулан задлан шинжлэх боломжтой.

Үнэлгээний даалгаврын төрөл	Гүйцэтгэлийн түвшин 1	Гүйцэтгэлийн түвшин 2	Гүйцэтгэлийн түвшин 3	Гүйцэтгэлийн түвшин 4
Бүтээлийн сан				
Ажиглалт				
Сорил туршилт				
Асуулт хариулт/Ярилцлага				
Нийт оноо				
Дундаж оноо				

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Мөнгөнтулга.Э., ба бусад. 2018. Эрүүл мэнд. Суурь, бага боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж. Улаанбаатар.
2. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Жаргал.Б., ба бусад. 2020. Бага боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж. Эрүүл мэндийн багшид зориулсан гарын авлага. VI-XII анги. Улаанбаатар.
3. Мөнгөнтулга.Э., Болорцэцэг.Д., Жаргал.Б., ба бусад. 2019. Эрүүл мэнд IV. Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийн сурах бичиг. Улаанбаатар.
4. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Мөнгөнтулга.Э., ба бусад. 2016. "Амьдрах ухааны чадвар" багц гарын авлага. Улаанбаатар.
5. Мөнгөнтулга.Э., Байгалмаа,Ч., Дийдэрмаа.Ц., ба бусад 2018. Эрүүл мэндийн боловсрол. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр боловсруулагч, сурах бичиг зохиогч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын гарын авлага
6. Болорцэцэг.Д., Дийдэрмаа.Ц., Энхтогтох.А., ба бусад. 2012. Үе тэнгийн сургагчдын үйл ажиллагаа. Үе тэнгийн сургагчдад зориулсан гарын авлага

ЕБС-ийн Эрүүл мэнд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

Ч.Байгалмаа

МУБИС-ийн БСС-ийн багш

Ц.Дийдэрмаа

Нийслэлийн ЕБ-ын 47 дугаар сургуулийн багш

Хөндлөнгийн шинжээч:

Э.Мөнгөтулга

МУБИС-ийн МБУС-ийн багш

Техникийн редактор:

Д.Энхжаргал

Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн, магистр

Ш.Сувдмаа

Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа

Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

Цаасны хэмжээ:

A4

Хэвлэлийн хуудас:

3 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-мэйл: info@eec.mn Вэб: www.eec.mn